



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/1586

Алтай хот

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
намрын дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27^{1.2} дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.10 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/191 дүгээр тушаал, аймгийн Онцгой комиссын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 12 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.


2. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад орон нутгийн төр захиргааны байгууллагууд, малчид мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийг татан оролцуулж, ажиллах хүч, хашаа хороо, тээврийн хэрэгсэл бусад шаардлагатай асуудлыг шуурхай шийдвэрлэж, тогтоосон хугацаанд зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Вакцин биобэлдмэл, халдвар хамгааллын хувцас, халдваргүйтгэлийн бодисыг хугацаанд нь татан авч хуваарилах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Д.Наянбуу)-т үүрэг болгосугай.

4. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах тээвэр шатахууны зардал 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг аймгийн Гамшгийн сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР